



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар *Б/23*

Хэрлэн сум

Ж.Гантулгыг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.20, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.3.2, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3, Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Жаргалын Гантулгыг 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Дарханбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Ш.Эрдэнэжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Э.Ариунтунгалаг Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

Д.Энхтуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

3.Ж.Гантулгад аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын үндсэн цалин, эрх бүхий албан тушаалтны 40 хувийн нэмэгдэл болон холбогдох бусад

нэмэгдлүүдийг хууль, журмын дагуу тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Гантулгад үүрэг болгосугай.

5.Ж.Гантулгад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.ЧОГСОМЖАВ